



**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7
Утас/Факс: (976-11) 32-71-99,
<http://www.ulaanbaatar.mn>

2018.04.30 № 03/1640
танай _____ -ны № _____ -т

**НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗАР, ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН
УДИРДЛАГУУДАД**

**Захирамжийн хэрэгжилтийг
ханган ажиллах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2012 оны 115 дугаар тогтоолоор батлагдсан "Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам", Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тогтоолоор батлагдсан "Журам шинэчлэн батлах тухай" тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2018 оны "Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын тухай" А/333 дугаар захирамж гарсан.

Дээрх шийдвэрүүдэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах, үнэлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулан, хариуцах байгууллага, албан тушаалтныг тодорхойлж, төлөвлөх, тайлагнах маягтыг хавсралтаар батлан, төлөвлөгөө, тайлангийн хугацааг тодорхой цаглабарт оруулан мөрдөж ажиллахаар баталсан.

Нийслэлийн хэмжээнд Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сан, урсгал төсөв, гадаадын зээл туламжийн хөрөнгө, өөрийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр тухайн онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэн холбогдох хууль тогтоомжийн дагуу нэгтгэн боловсруулан батлуулж, холбогдох газруудад хүргүүлэх ажлыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар хариуцан хэрэгжүүлэхээр болсон.

Иймд нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллагын удирдлагууд дээрх хөрөнгийн эх үүсвэрээр тухайн онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг холбогдох хууль, журмаар батлагдсан маягтын дагуу боловсруулж, хуульд заасан хугацаанд нь Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн, нийслэлийн Шилэн тендерийн бүртгэлийн системд оруулж ажиллах шаардлагатай байна.

Мөн Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолд "Худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж, олон



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/333

Улаанбаатар хот

Худалдан авах ажиллагааны зохион
байгуулалтыг сайжруулах зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4, 49 дүгээр зүйлийн 49.5, Засгийн газрын 2012 оны 115 дугаар тогтоол, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламж болон бусад эх үүсвэрээр тухайн онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг баталсан маягтын дагуу боловсруулан батлуулж, зохих журмын дагуу холбогдох газарт хүргүүлэн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж ажиллахыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар /Б.Гүндсамбуу/-т, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг тогтоосон хугацаанд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж, шилэн тендерийн бүртгэлийн системд оруулж ажиллахыг нийслэлийн төр, захиргааны байгууллага, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөвт байгууллагын удирдлагуудад тус тус даалгасугай.

2. Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө, тайланд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Дотоод аудитын алба /Б.Жавзан/-нд, тайланг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, улирал бүр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж байхыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс /Х.Гантулга/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Тайлан мэдээ нэгтгэх тухай" Нийслэлийн Засаг даргын 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1148 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД

нийтэд мэдээлэх", Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-74 дэх хэсэгт "Худалдан авах ажиллагааны нэгдсэн мэдээллийн системийг нийслэлийн хэмжээнд нэвтрүүлэн нутгийн захиргааны байгууллагуудыг тухайн системд нэгтгэх ажлыг хэрэгжүүлж, бүрэн ил тод нээлттэй болгох" зорилтыг хэрэгжүүлэн Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төлөвлөгөөнд батлагдсан нийт худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр зохион байгуулж, урилга, үр дүнг тухай бүр нийтлэн ил тод, нээлттэй байдлыг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг байгууллага нэг бүрээр гарган улирал бүр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн үнэлнэ. Худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулаагүй, төлөвлөгөө, тайланг хуульд заасан хугацаанд нь батлагдсан маягтын дагуу ирүүлээгүй байгууллагын удирдлагад хариуцлага тооцон ажиллахыг мэдэгдье.

Хавсралтаар Нийслэлийн Засаг даргын 2018 оны "Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын тухай" А/333 дугаар захирамжийг хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай

ДАРГА



М.ОТГОНБАЯР